



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар В/405

Улаанбаатар хот

□ Барилга байгууламж данснаас хасах тухай □


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 8/73 дугаар, 2018 оны 20/21 дүгээр тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2019 оны 5 дугаар, 2020 оны 2 дугаар, 8 дугаар, 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянгол дүүргийн 7 дугаар хороо, 4 дүгээр хорооллын эцсийн Үйлчилгээний төвд байрлах 145,978,903 /нэг зуун дөчин таван сая есөн зуун далан найман мянга есөн зуун гурав/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий "Монгол шуудан" ХК-ийн 23 дугаар салбарын түрээсээр эзэмшиж байсан байрыг хувьчилсан тул данс бүртгэлээс хасахыг Ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГ



Ш.ҮНЭНБАТ

115050000961